

**ХУУЛЬЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН
НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН
ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2021 оны 05 дугаар
сарын 19-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч: Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2021 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны нэр томъёоны тодорхойлолтыг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн өргөн хүрээнд тусгах, эрх зүйч мэргэжлээр төгссөн хүнийг хуульчаар ажиллах боломжийг нэмэгдүүлэх, ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхийг хангах, түүнчлэн Хуульчдын холбооны гишүүнчлэлийн асуудал болон хуулийг хэрэгжүүлэх явцад гарсан давхардал, хийдэл, зөрчлийг арилгаж, зохицуулалтыг боловсронгуй болгох зорилтын хүрээнд хуулийн төслийг боловсруулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр Улсын Их Хурлын гишүүний зөвлөх, туслахуудаар ажилласан хугацааг эрх зүйч мэргэжлээр ажиллаж мэргэжлийн дадлага хийсэнд тооцохгүй байх зохицуулалтын үндэслэл, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хангалттай итгэл үнэмшил, хандлага тогтсон гэснийг хэн тогтоож, хэрхэн үнэлэх, түүнчлэн хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл нь түдгэлзсэн төрийн байгууллагад ажиллаж байгаа хуульч үргэлжилсэн сургалтад хамрагдаагүй тохиолдолд зөвшөөрөл нь хүчингүй болох эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар Улсын Их Хурлын гишүүнийг эрх зүйч мэргэжлээр ажилласанд тооцох эсэх, Хуульчдын Их Хурлыг бүрдүүлэх төлөөллийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд Хуульчдын холбоо нь зайлшгүй байх шаардлагатай байгууллага мөн эсэх, эрх зүйн их дээд, эчнээ ангийн төгсөгч хуульчийн шалгалт өгөх эрхтэй эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт үе үеийн Хуульчдын холбооны Ерөнхийлөгчийг сонгох асуудал маргаан дагуулж ирснийг хэрхэн зохицуулсан, эрх зүйн ангийн оюутны заавал судлах багц цаг болон суралцах жилийг багасгасан үндэслэл, түүнчлэн хуульч мэргэжлийн үйл ажиллагааны зөрчил гаргасан тохиолдолд хэнд хандаж шийдвэрлүүлэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр Хуульчдын холбооны Ерөнхийлөгчийг хоёр жил тутам сонгодог байсныг дөрвөн жил тутам сонгодог болгох нь Хуульчдын холбоог төрийн байгууллагын хэв шинж, тогтолцоонд шилжүүлж байна гэж үзэж байгаа тул хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжихгүй талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар хуулийн төслийг хэлэлцэхийг дэмжиж байгаа хэдий ч Хуульчдын холбооны статус, чиг үүргийг тодорхой болгох шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн Ш.Раднаасэд Хуульчдын холбоо нь эрх зүйч бэлтгэх дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг зохион байгуулах, хяналт тавих ажилд оролцох шаардлагагүй талаар санал хэлсэн болно.


Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 53.3 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хууль хүчингүй болсонд тооцох тухай, Нотариатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нотариатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хууль хүчингүй болсонд тооцох тухай, Дээд боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



С.БЯМБАЦОГТ